



Мэндчилгээ

Сайханчуудынхаа алар мэндийг айлтган мэндчилье.

Адуу айргаараа, алдар цуутнуудаараа, аварга хүчит бөхчүүдээрээ, алдарт Сайхан нутагт маань зундаа хур бороо тэгширэн өвө ургамлын гарц сайтай, намартаа шаргал нар эзсэн налгар сайхан намар болж, өвөлдөө өнтэй сайхан өвөл болж, тарган тавтай сайхан өвөлжиж байна.

Орон нутгийн ээлжит сонгууль болж, сонгуулийн үр дүнгээр сонгогдсон УТХ-ын дарга, БУБХурлын дарга, дүж шатны Засаг дарга нар томилогдон ажилдаа орлоо.

Сумын 7 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаан хуралдаж, сумын УТХ-ын 2017-2020 онд баримтлан ажиллах үндсэн чиглэл, 2017 оны зорилго, зорилтоо дэвшүүлж, төсвөө баталж, сумын Засаг даргын “Сумандаа сайхан амьдаръя” 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө иргэдээр хэлэлцүүлж, УТХ-аар батлууллаа. Дэвшүүлсэн зорилт, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, нутаг орноо хөгжүүлэхэд иргэн дүр санаачлагатай, ажилсаг хөдөлмөрч байдлыг эрхэмлэсэн, нийтээрээ нэг зорилготой, нэгдмэл санаатай, эв нэгдэл, ил тод байдлыг хангаж ажиллахыг уриалж байна.

Өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж, сум орныхоо хөгжил дэвшлийн төлөө бид дүжэн идэвхийлэн ажиллаж болно.

Сайханчууд та дүжэндээ эрүүл энх, ажил хөдөлмөр нь бүтэмжтэй, амьдрал ажуй нь өөдрөг, зам мөр нь зөв, заяа дүян тэгш байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүлье.

УТХ-ын дарга

Д.Сансар-Очир

Засаг дарга

Д.Дорждагва